

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ I УЛИРЛЫН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ЯВЦЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

2025.04.30

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт нь хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэхийг нягтлах, арга хэмжээ тус бүрийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай санал, зөвлөмжийг боловсруулах, шийдвэр гаргагч нарт холбогдох мэдээлэл өгөх зорилгоор хяналт-шинжилгээг хийсэн.

Хоёр. Хяналт-шинжилгээ үнэлгээний арга зүй

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 4.4 дүгээр заалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны "Аргачлал, загвар батлах тухай" 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу тус газрын **Захиргаа, төлөвлөлт удирдлагын хэлтэс нь** байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэж, **Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст** телеграмаар ирүүлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 6.2.1, 6.2.2 болон 6.7 дугаар заалтуудыг үндэслэн Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны төлөвлөгөөний I улирлын биелэлтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэсэн. Үнэлгээг бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хувийг тодорхойлох аргачлалаар тооцон гаргасан болно.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн


Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 62 (82 шалгуур үзүүлэлт) үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаас 5 ажил буюу нийт ажлын 8.1% нь 100 хувийн хэрэгжилттэй, 3 ажил буюу 4.8% нь 90 хувийн хэрэгжилттэй, 3 ажил буюу 4.8% нь 70 хувийн хэрэгжилттэй, 4 ажил буюу 6.5% нь 50 хувийн хэрэгжилттэй, 11 ажил буюу 17.7% нь 30 хувийн хэрэгжилттэй, 29 ажил буюу 46.8% нь 0-29 хувийн хэрэгжилттэй, 7 ажил буюу 11.3% нь хугацаа болоогүй байгаа ба НЭМГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний I улирлын биелэлт 31.7% буюу "эрчимжүүлэх шаардлагатай" гэж үнэлэгдэв.

Хүснэгт 1. Хяналт-шинжилгээний чанарын үзүүлэлт

Үнэлгээ	Арга хэмжээ	
	Тоо	Эзлэх хувь
100 хувь буюу "бүрэн хэрэгжсэн"	5	8.1%
90 хувь буюу "зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа"	3	4.8%
70 хувь буюу "тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа"	3	4.8%
50 хувь буюу "тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн"	4	6.5%

30 хувь буюу "тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа"	11	17.7%
0 хувь буюу "тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй"	29	46.7%
Нийт	62	100%
Дундаж	31.7%	

Зураг 1. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний I улирлын биелэлтийн злэх хувь



Хүснэгт 3. 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт (хариуцсан нэгжээр)

№	Хэлтсийн нэр	2025 онд төлөвлөсөн нийт ажил	Төлөвлөгөөнд эзлэх хувь	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь						
				100%	90%	70%	50%	30%	0-29%	ХБ
1.	ЗТУХ	17	27.4%				1	7	8	1
2.	ЭТХ	8	12.9%	1				2	3	2
3.	ЭМДХБӨХ	8	12.9%			1	1	2	1	3
4.	НЭАХӨХ	5	8.1%						5	
5.	СХОХ	16	25.8%	3		2	2		9	
6.	ЭМХХ	3	4.8%		2				1	
7.	ХШҮДАХ	4	6.5%	1	1				1	1
8.	Ажлын хэсэг	1	1.6%						1	
	Нийт	62	100%	5	3	3	4	11	29	7

Дөрөв. Дүгнэлт

- Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний I улирлын хэрэгжилтийн гүйцэтгэл 31.7% байгаа нь “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдэв.
- Төлөвлөгөөнд 62 ажил батлагдсанаас 70% түүнээс бага буюу хэрэгжилт хангалтгүй 47 ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Энэ нь нийт ажлын 75%-ийг эзэлж байна.
- Хэлтийн дарга нар Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний I улирлын хэрэгжилтийн тайланг хянаагүй шууд ЗТУХ-т ирүүлсэн алдаатай байна.
- ЗТУХ нь Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг I улирлын хэрэгжилтийг нэгтгэхдээ хэлтсүүдээс ирүүлсэн тайланг шууд хуулж тавьсан, үг үсэг, утга найруулгын алдааг хянаагүй.
- Төлөвлөгөөнөөс 2 арга хэмжээг (2.4, 2.22) тайлагнаагүй хоосон хүснэгт ирүүлсэн, тайлангийн огноо байхгүй алдаатай байна.
- Төлөвлөгөөний заалт зорилтод хамааралгүй арга хэмжээний хэрэгжилт (2.1, 2.15, 4.13, 5.13) тайлагнасан.
- Тайланг үг үсэг, утга найруулгын алдаатай, шалгуур үзүүлэлтийн дагуу бичээгүй.

Тав. Зөвлөмж

1. Тайланг хугацаанд нь оновчтой, **шалгуур үзүүлэлтийн дагуу** 2000 тэмдэгтэд багтаан, тодорхой, зөв бичих.
2. Тайланг хувь хүн бус байгууллагын нэрийн өмнөөс бичих.
3. Тайланг бичихдээ албаны үг хэллэг хэрэглэж, үг үсэг утга найруулгын алдаагүй, товчилсон үг хэрэглэхгүй бичих.
4. Тайланд албан бичиг, тушаал, захирамж бичигдэж байгаа тохиолдолд албан бичиг, тушаал, захирамжийн огноо, дугаарыг заавал оруулах.
5. Төлөвлөгөөний заалт зорилтод хамааралтай арга арга хэмжээг тайлагнах.
6. Хэлтийн дарга нар Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хянаж, гарын үсгээр баталгаажуулан ЗТУХ-т өгч хэвших.
7. ЗТУХ нь хэлтсүүдээс ирүүлсэн тайланг нэгтгэхдээ үг үсэг, утга найруулгын алдааг хянах, шаардлагатай бол хэлтсүүдэд буцаах, арга хэмжээ тус бүрийг бүрэн тайлагнасан байхад анхаарах.
8. 70% түүнээс бага хэрэгжилттэй 47 ажлыг эрчимжүүлэн ажиллах.

Хяналт шинжилгээний дүнд нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний нэгдүгээр улирлын хэрэгжилт, зөвлөмж 37 хуудас тайланг хасаргав.

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС